



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/145

Арвайхээр

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд
дэмжлэг үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үеийн ачаалал, хүнд нөхцөл байдлыг харгалзан Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эрчимт эмчилгээний тасгийн эмч, сувилагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахад зориулсан тавилга, тоног төхөөрөмжийн санхүүжилтэд 2,683,900 (хоёр сая зургаан зуун наян гурван мянга есөн зуу) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Нягтлан бодогч (Ж.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАТ